БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/147/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг

2022 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: З.Ганбаатар
Утас: 70342495 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ................................................ **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ................................................ 4
3. Аудитын тайлан................................................................................................ 9
3.1 Ерөнхий зүйл................................................................................................ 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .......... **Error! Bookmark not defined.**
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................ 10
3.4 Материаллаг байдал ........................................................................................ 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга...................................................................... 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..................................................... 10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг............................................ 11
3.8 Аудитын гол асуудал ...................................................................................... 11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........... 11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................................................ 12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал............................................................ 12
4. Аудитын илрүүлэлт ......................................................................................... 12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ...................................................... 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

**БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 129

танай ______ ны № ______ т

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.БАТТУЛГА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Цалингийн зардлаас 317,894.50 /гурван зуун арван долоон мянга найман зуун ерэн дөрвөн төгрөг тавь/ мөнгөний ажил олгогчийн НДШ-ийн зардалд, бичиг хэргийн зардлаас 942,000.00 /есөн зуун дөчин хоёр мянга/ хичээл үйлдвэрлэлийн зардлаас 783,110.00 /долоон зуун наян гурван мянга нэг зуун арав/, урсгал засварын зардлаас 1,620,200.00 /нэг сая зургаан зуун хорин мянга хоёр зуу/, шатахууны зардлаас 255,950.00 /хоёр зуун тавин таван мянга есөн зуун тавь/ төгрөгийг тус тус шууд зардалд бичиж нийт 3,919,154.50 /гурван сая есөн зуун арван есөн мянга нэг зуун тавин дөрвөн мянга тавь/ мөнгө бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан;

D:/bichighereg/2022A4toot

006020066

- Тайлан онд ЗДТГ-аас өртгөө бүрэн элэгдүүлсэн авто машиныг шилжүүлэн авч бүртгэхдээ бодит үнэ цэнээр бүртгээгүй зөрчлүүд нь Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийн 5.4.2-ын 5 дахь заалтын "г", төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 271 дүгээр тогтоолын 5.6 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2, 71.2, 73.2 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой, оршин байх, үнэн зөв, ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 3,195,100.00 | 4,131,090.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 3,195,100.00 | 4,131,090.00 |
| 354 | Хангамжийн материал | 3,195,100.00 | 4,131,090.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,330,700.00 | 1,953,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,804,400.00 | 1,914,790.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 60,000.00 | 263,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 29,165,833.08 | 16,964,328.67 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 29,165,833.08 | 16,964,328.67 |
| 392 | Биет хөрөнгө | 29,165,833.08 | 16,964,328.67 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 22,866,666.67 | 72,900,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (6,756,944.60) | (70,315,277.98) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 21,093,984.79 | 26,373,784.79 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (13,834,260.99) | (16,303,206.51) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17,073,593.50 | 17,073,593.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,277,206.29) | (12,764,565.13) |
| 39301 | Програм хангамж | 480,000.00 | 480,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (480,000.00) | (480,000.00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 32,360,933.08 | 21,095,418.67 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 32,360,933.08 | 21,095,418.67 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 32,360,933.08 | 21,095,418.67 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 12,583,044.34 | 12,583,044.34 |
| 51101 | Өмч: - төрийн | 12,583,044.34 | 12,583,044.34 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 19,777,888.74 | 8,512,374.33 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 15,954,893.99 | 15,954,893.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 3,822,994.75 | (7,442,519.66) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 32,360,933.08 | 21,095,418.67 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 122,290,700.00 | 140,809,600.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,055,000.00 | 8,760,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,880,000.00 | 7,510,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,880,000.00 | 7,510,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,880,000.00 | 4,090,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 3,220,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 200,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | 175,000.00 | 1,250,000.00 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 175,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 114,235,700.00 | 132,049,600.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 350,000.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 350,000.00 | - |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 113,885,700.00 | 132,049,600.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 113,885,700.00 | 132,049,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 132,768,296.92 | 143,108,447.74 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 132,768,296.92 | 143,108,447.74 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 123,282,997.44 | 129,632,566.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 92,100,165.25 | 90,589,082.58 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 81,820,961.76 | 64,279,579.95 |
| 210102 | Нэмэгдэл | 720,045.49 | 24,553,202.63 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,246,010.00 | 1,756,300.00 |
| 210104 | Урамшуулал | 7,313,148.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 11,502,314.15 | 12,139,239.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,847,109.59 | 9,247,363.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 913,801.14 | 803,686.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 731,040.91 | 642,949.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 182,760.23 | 131,385.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,827,602.28 | 1,313,853.82 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,888,891.12 | 9,884,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,931,211.12 | 5,112,860.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,571,500.00 | 4,299,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 594,780.00 | 386,890.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 85,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 30,000.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,761,400.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000,000.00 | 1,717,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,717,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,258,000.00 | 1,695,667.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,258,000.00 | 1,695,667.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 401,630.00 | 1,482,430.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 143,550.00 | 74,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 106,080.00 | 36,180.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,350,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,131,996.92 | 12,124,447.74 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,142,900.00 | 3,609,810.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,989,096.92 | 8,514,637.74 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,485,299.48 | 13,475,881.28 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,700,000.00 | 2,050,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,700,000.00 | 2,050,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,785,299.48 | 11,425,881.28 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,785,299.48 | 11,425,881.28 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (10,477,596.92) | (2,298,847.74) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 8,966,666.67 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 8,966,666.67 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (8,966,666.67) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (10,477,596.92) | (11,265,514.41) |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 12,583,044.34 | - | **19777888.74** | 32,360,933.08 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 12,583,044.34 | - | 19777888.74 | 32,360,933.08 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (11,265,514.41) | (11,265,514.41) |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 12,583,044.34 | | 8,512,374.33 | 21,095,418.67 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 122,290,700.00 | 139,359,600.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,055,000.00 | 7,310,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,880,000.00 | 7,310,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,880,000.00 | 7,310,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,880,000.00 | 4,090,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 3,220,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | 175,000.00 | - |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 175,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 114,235,700.00 | 132,049,600.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 350,000.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 350,000.00 | - |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 113,885,700.00 | 132,049,600.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 113,885,700.00 | 132,049,600.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 125,465,700.00 | 140,609,600.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 125,465,700.00 | 140,609,600.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 115,980,400.52 | 127,133,718.72 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 89,701,782.10 | 90,906,977.07 |
| 210101 | Үндсэн цалин | 66,950,305.36 | 65,994,879.15 |
| 210102 | Нэмэгдэл | 20,011,658.11 | 23,157,799.08 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,739,818.63 | 1,754,298.84 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 11,800,697.30 | 11,821,344.65 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,692,691.09 | 8,398,748.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 277,001.54 | 1,086,351.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 221,601.25 | 715,302.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 55,400.30 | 147,358.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 554,003.12 | 1,473,583.39 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,537,791.12 | 11,291,990.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,493,011.12 | 6,444,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,240,000.00 | 4,299,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 594,780.00 | 386,890.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 11,250.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 210,000.00 | 150,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,980,000.00 | 7,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,980,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 2,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,258,000.00 | 1,695,667.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,258,000.00 | 1,695,667.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 401,630.00 | 1,482,430.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 143,550.00 | 74,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 106,080.00 | 36,180.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,350,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,300,500.00 | 2,935,310.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,300,500.00 | 2,935,310.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,485,299.48 | 13,475,881.28 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,700,000.00 | 2,050,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,700,000.00 | 2,050,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5,785,299.48 | 11,425,881.28 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,785,299.48 | 11,425,881.28 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (3,175,000.00) | (1,250,000.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (3,175,000.00) | (1,250,000.00) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 126049200.00 | 129183718.62 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 126049200.00 | 129183718.62 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 124549200.00 | 127133718.62 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 88916500.00 | 90906977.07 |
| 210101 | Үндсэн цалин | 62386500.00 | 65994879.15 |
| 210102 | Нэмэгдэл | 23989000.00 | 23157799.08 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2541000.00 | 1754298.84 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 12138200.00 | 11821344.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8541700.00 | 8398748.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 898900.00 | 1086351.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 719500.00 | 715302.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 179400.00 | 147358.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1798700.00 | 1473583.29 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8702500.00 | 11291990.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5750000.00 | 6444100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2000000.00 | 4299750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 415,000.00 | 386,890.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 312,500.00 | 11,250.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 225,000.00 | 150,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,000,000.00 | 7,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,150,000.00 | 1,695,667.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,150,000.00 | 1,695,667.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,682,000.00 | 1,482,430.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 150,000.00 | 74,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 138,000.00 | 36,180.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,960,000.00 | 2,935,310.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,960,000.00 | 2,935,310.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,500,000.00 | 2,050,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,500,000.00 | 2,050,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 2,050,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 130,656,700.00 | 149,169,600.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 124,906,700.00 | 140,609,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 124,906,700.00 | 140,609,600.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 4,250,000.00 | 7,310,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,250,000.00 | 7,310,000.00 |
| 122 | ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ | 1,500,000.00 | 1,250,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 1,500,000.00 | 1,250,000.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 3,220,000.00 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,220,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 3,220,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 3,220,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 3,220,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн ОНӨГ нь орон нутгийн өмчийн бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн орон нутгийн өмчийн газрын бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ОНӨГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 132,768.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 929. мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн ОНӨГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,265.5 мянган төгрөгөөр буюу 34.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мян.төг /

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0 | 00 | 0 |
| 0Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 3,195.1 | 4,131.1 | 935.9 |
| Үндсэн хөрөнгө | 29,165.8 | 16,964.3 | 12,201.5 |
| Нийт хөрөнгө | 32,360.9 | 21,095.4 | 11,265.5 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 12,583.0 | 12,583.0 | 0 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 32,360.9 | 21,095.4 | 11,265.5 |

**Авлага:** Тайлант онд авлага үүсээгүй байна.

**Бараа материал:** Бараа материалын дансны үлдэгдэл 4,131.1 мянган төгрөг болж 935.9 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материалыг дутуу зарцуулснаас шалтгаалж байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 16,964.3 мянган төгрөг болж 12,201.5 мянган төгрөгөөр буурсан нь тухай жилийн элэгдэл болон үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлсэн хөрөнгөөс үүссэн байна.

**Өр төлбөр:** Тайлант онд өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 147.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 147.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 10.0 сая төгрөгөөр бууруулан 137.0 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 137.0 сая төгрөгийн төсөв батласнаас 132.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5 сая үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 132.0 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 7.3 сая бусад орлого 0.2 сая төгрөг нийт 7.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5.0 сая төгрөгийг зарцуулж 2.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 2.3 хувиар буюу 4,879.9 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан,

**3.8 Аудитын гол асуудал**

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, 6.10, дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Үндсэн хөрөнгийн тавилга хэрэгслийн дансанд 1 төрлийн 239900 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй тоног төхөөрөмж бүртгэлтэй байгаа нь УСНББОУС 17, 14а, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил бүрэн хэрэгжсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 81,214.7 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 16,505.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 650.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 64,059.1 мянган төгрөгийн 4 алдаа зөрчлийг арилгах албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 16,505.7 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй байсныг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Анхан шатны баримтгүй 650000 төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Цалингийн зардлаас 317894.5 төгрөгийг ажил олгогчийн НДШ-ийн зардалд, бичиг хэргийн зардлаас 942000, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 783110, урсгал засварын

зардлаас 1620200 төгрөгийг авто машины дугуйны зардалд, шатахууны зардлаас 255950 төгрөгийг авто машины засварын зардалд нийт 3919154.5 төгрөгийг бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зориулалт бус зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага.

4.4 Албан шаардлага

Үндсэн хөрөнгийн тавилга хэрэгслийн дансанд 1 төрлийн 239900 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй тоног төхөөрөмж бүртгэлтэй байгаа нь УСНББОУС 17, 14а, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага.

4.5 Албан шаардлага

Тайлан онд ЗДТГ-аас өртгөө бүрэн элэгдүүлсэн авто машиныг шилжүүлэн авч бүртгэхдээ бодит үнэ цэнээр бүртгээгүй нь Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар баталсан НББББББ-ийн 5.4.2-ын 5 дахь заалтын "г", төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 271 дүгээр тогтоолын 5.6 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага.

4.5 Албан шаардлага

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, 6.10, дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага.

4. Зөвлөмж

**Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:**

***1. Авлагын данстай холбоотой асуудал***

1.1. *Илрүүлэлт:*

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна. гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

*Өгсөн зөвлөмж:*

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

*/Мян.Төгрөгөөр/*

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ОНӨГ | 8 | 81.3 | 2 | 16.5 | 1 | 0.7 | 4 | 64.1 | 1 | 0 |
| Нийт дүн | | 8 | 81.3 | **2** | 16.5 | 1 | 0.7 | 4 | 64.1 | 1 | 0 |